



УС

БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Гүний хоолой болон Ханбогдын бүс нутгийн малчид, ард иргэдийн усан хангамж болон усны чанарыг хамгаалах үйл ажиллагааг дэмжих
- Бүс нутгийн ард иргэдийн усан хангамжийг сайжруулахад туслалцаа үзүүлэх.

ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Гүний Хоолойн гүний уст давхарга болон Оюу Толгой - Гашуун Сухайтын замын барилгын ажлын явцад ашиглагдах бусад уст давхаргуудын усны түвшин буурах
- Гүний Хоолойн уст давхаргын гүний усыг ашигласнаас үүдэх бүсийн гүний усны нөөц шавхагдах боломж
- Гадаргуун усны нөөц болон гүехэн уст давхаргын усны чанарт үзүүлэх боломжит нөлөөлөл
- Усны анхан шатны хайгуулын өрмийн цооногийн усны алдагдлаас үүсэх гүехэн уст давхаргад үзүүлэх нөлөөлөл
- Ил болон далд уурхайн эргэн тойрны гүехэн уст давхаргын усны түвшин буурах.

БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН СОНГОЛТ:

- Малчдын ашиглаж буйгаас илүү гүнд орших уст давхаргын гүний усыг (Жишээ нь Гүний Хоолой) уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаанд ашиглах.



УС ХАМГААЛАЛТ, ХЭМНЭЛТИЙН ҮР АШИГТ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДЭЭР ТУЛГУУРЛАН УС АШИГЛАЛТЫГ БУУРУУЛАХ:

- Боломжтой тохиолдолд ус бага ашигладаг эсвэл ус үл ашиглах технологийг хэрэгжүүлэх (Жишээ нь агаарын хөргөлттэй эрчим хүчний систем)
- Ус хамгаалалт, хэмнэлтийн хамгийн сүүлийн үеийн арга техникийг ашиглах
- Ус дахин ашиглах, эргүүлэн ашиглах арга техникүүдийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлсэнээр нийт ашигласан усны 80%-ийг эргүүлэн гарган авч, гаргаж авсан усыг 100% дахин ашиглах
- Гүний Хоолойн тогтоогдсон усны нийт нөөцийн 20 хүрэхгүй хувийг 40 жилийн хугацаанд ашигласнаар усны дийлэнх нөөцийг ирээдүй хойч үед үлдээх.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ:

- Оюу Толгой уурхайн ус ашиглалтын цогц хяналт шинжилгээ хийн орон нутгийн малчдын худаг, уурхайн талбайгаас гаднах булаг шандад ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байгааг баталгаажуулах
- Нийт 245 өрмийн цооног, малчдын худаг болон булаг шандыг хамарсан бүс нутгийн усны цогц хяналт шинжилгээний хөтөлбөрийг үргэлжлүүлэн (2003 оноос хойш) хэрэгжүүлэх
- Байгаль орчны оролцооны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн ард иргэд, малчидтай үргэлжлүүлэн хамтран ажиллах.

ХАМГААЛАЛТ:

- Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хог хаягдлыг ашиглах, хадгалах, зөв зохистой зайлуулах замаар усны чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах
- Уурхайн талбай дахь үйлдвэрийн бүсүүдийн эргэн тойрны борооны усны урсцыг усны чанарт нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх зорилгоор өөрчлөн урсгаж, замаас барьж авч цуглуулах
- Гадаргуун урсцыг хамгаалах зорилгоор Ундай голын голдрилд хэсэгчилсэн тохируулга хийх (Дэлгэрэнгүй мэдээллийн Ундай голын тухай баримтын хуудаснаас үзнэ үү)
- Усны алдагдал, гоожилт үүссэн худгуудыг таглах, битүүмжлэх.

ОРОН НУТГИЙН АРД ИРГЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ:

- Бидний үйл ажиллагаанаас үүдэн ямар нэгэн нөлөөлөл үүсэхэд усны хэмжээ болон чанарын зохистой хангамжийг баталгаажуулахын тулд ямар нэгэн нөлөөллийг хамрагдсан малчидтай зөвшилцөх замаар бууруулах
- Малчдын хуучирсан болон эвдэрсэн худгуудыг шинэчлэхэд үзүүлж буй дэмжлэгээ үргэлжлүүлэх (одоогоор 20 гар худгийг шинэчлээд байгаа).

УСНЫ ШИНЭ ЭХ ҮҮСВЭРИЙН ХАЙГУУЛЫГ ДЭМЖИХ:

- Оюу Толгойн ашиглалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх ирээдүйн усны эх үүсвэрийг төслийн талбайн ойролцоо цогц байдлаар хайх үйл ажиллагааг үргэлжлүүлэх
- Сумын төвүүдийн урт хугацааны усан хангамжийн эх үүсвэрийг илрүүлэх зорилгоор орон нутгийн сумдаар усны цогц хайгуул хийх үйл ажиллагааг үргэлжлүүлэх.

Түүнчлэн бидний зүгээс 1.7 тэрбум төгрөгийг Ханбогд сумын усны шинэ эх үүсвэрийг хайх, судлахад (геофизикийн судалгаа болон хайгуул) зориулан зарцуулаад байна. Цаашид туршилт, хайгуул, загварчлалын үйл ажиллагааг гүйцэтгэн усны эх үүсвэрийн тогтвортой хөгжлийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад ашиглана.



Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Усны менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г www.ot.mn цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.